



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР НЬ ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭГ
БОДИТОЙ ДҮГНЭДЭГГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ,
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: АРА-2025/32-ШТА-ГА

Архангай аймаг 2025 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneeg@audit.gov.mn

Аудитор Н.Дашмягмар

Утас: 99164656 Цахим хаяг: Dashmyagmam@audit.gov.mn

Аудитор Б.Азантунгалаг

Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

**Тайлан бэлтгэсэн:**Архангай аймаг дахь
Төрийн аудитын газар

- Товчилсон үгийн тайлбар 2
- Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4-5
- Үндсэн мэдээлэл 6-7
- Аудитын тайлан 8-31

Тэргүүлэх аудитор
Т.БайгалмааАудитын менежер
Д.НэргүйбаатарАхлах аудитор
Г.Цог-ЭрдэнэАудитор
Б.Азантунгалаг
Н.Дашмягмар2025 оны 06 дугаар сар
Уг тайланг
www.audit.mn сайтаас
үзнэ үү.Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах зүйл байвал
7033-2860 дугаарын
утас, 7033-3141
дугаарын факсаар
харилцана ууХаяг:
Эрдэнэбулган
сум Аймгийн
ЗДТГ-ын байр
3-р давхар 314 тоот**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ,
БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН
БАЙГУУЛААГҮЙ БАЙНА****А.1** Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлээгүй байна**А.2** Аудитаар түүвэрт хамруулсан байгууллагын 95 хувь нь хуульд заасан хугацаанд тооллогыг зохион байгуулсан ч 355.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна**А.3** Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлах доод үнийг үндэслэлтэй тогтоогоогүй, дуудлага худалдааны талаар олон нийтэд цахимаар мэдээлээгүй байна.**А.4** Орон нутгийн өмчийн хөрөнгийг актлах, данснаас хасах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ,
ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ ХАНГАЛТГҮЙ БАЙНА****Б.1** Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн орлогын төвлөрүүлэлт 76.9 хувьтай, ашиглалтад хяналт тавьж ажиллаагүй байна**Б.2** Аймгийн хэмжээнд орон нутгийн эд хөрөнгийн тооллогын дүн нэгтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлээгүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна**Б.3** Орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, 427.4 сая төгрөгийн хөрөнгө дутагдуулсан байна

Дүгнэлт.....	23
Зөвлөмж	24
Холбогдох байгууллагын санал	25
Тайлан баталгаажуулсан тушаал.....	26-28
Хавсралт:Судалгаанууд	29-33



**Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АИТХТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
БХБС	Барилга хот байгуулалтын Сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өөрчлөлт /2023, 2024 он/	6
Хүснэгт 3	Хөрөнгийн хэмжээг үйл ажиллагааны салбараар авч үзвэл	7
Хүснэгт 4	2023-2024 онд шинээр нэмэгдсэн эх үүсвэрийн төрлөөр авч үзвэл	
Хүснэгт 5	Сүүлийн 2 жилд шинээр нэмэгдсэн хөрөнгийг үйл ажиллагааны салбараар авч үзвэл	9
Хүснэгт 6	ОНӨААТҮГ-ийн хөрөнгө оруулалтын жагсаалт	10
Хүснэгт 7	Дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн тоо, төвлөрүүлсэн дүн /2023, 2024 он/	12
Хүснэгт 8	Нийт хасагдсан хөрөнгийн жагсаалт	13
Хүснэгт 9	Орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгийн 2023, 2024 оны төвлөрүүлэлтийн байдал	16
Хүснэгт 10		

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Орон нутгийн өмчийн газрын бүтцийн өөрчлөлт	6
2	Санал асуулгын дүн	7
3	Зөвшөөрлийн дагуу бэлтгэсэн хөрөнгө /2023, 2024 он/	9
4	Санал асуулгын дүн	14
5	Акталсан хөрөнгийн нэгтгэл /2023, 2024 он/	15
6	Санал асуулгын дүн	16

**Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудит
хийсэн
үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын
зорилт

“Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх үйл ажиллагаа хууль журмын дагуу оновчтой зохион байгуулсан эсэх;*
- *Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй эсэх;*

Аудитын
хамарсан хүрээ

Аудитад орон нутгийн төсвийн байгууллага¹ 167, ОНӨААТҮГ-9, нийт 176 хуулийн этгээд (цаашид орон нутгийн өмчит хуулийн этгээд гэх) байгууллагын 2023, 2024 оны өмч хөрөнгө олж бэлтгэх, ашиглах захиран зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой баримт материал болон хөрөнгийн хөдлөлийг хамруулав.

Аудитын явцад 81 байгууллагыг түүвэрт хамруулан эзэмшилд бүртгэлтэй хөрөнгийг хяналтын тооллого хийж, баталгаажуулан албан хаагчдаас өмч хөрөнгө олж бэлтгэх, ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой санал асуулгыг авч аудитын 4 дэх түвшний асуудал бүрээр дүнг нэгтгэн тайлагнав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардлагатай бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, холбогдох албан тушаалтнаас хяналтын хуудсаар асуулга лавлагаа, тодруулга авах, орон нутгийн өмчит хуулийн этгээдээс түүвэрлэн үндсэн хөрөнгийн хяналтын тооллогыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

¹Төсвийн тухай хуулийн 4.1.34-т “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг”



Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; ✓ Төсвийн тухай хууль; ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; ✓ Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам /ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоол; ✓ Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам ТӨБЗГ-ын 2022 оны 65 дугаар тогтоол; ✓ Аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаар тогтоол /Орон нутгийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам; ✓ Өмч хөрөнгийг хувьчлах, актлахтай холбоотой аймаг, сумын ИТХ-ын 2023, 2024 оны тогтоолууд; ✓ Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам батлах тухай /Аймгийн засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/452 тоот захирамж; ✓ Төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам /МУЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоол; ✓ ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 715 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх аргачлал" ✓ Холбогдох бусад хууль, дүрэм, журам;
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Б.Азантунгалаг, Н.Дашмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025.05.20-2025.06.20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Аудитад 2023-2024 оныг хамруулан үзсэн ба тухайн үед ажил хариуцаж байсан албан тушаалтнууд солигдсон, өмчийн бүртгэлийн программ шинэчлэл хийгдэж байгаатай холбоотой өөрчлөлтийг салбараар гаргах боломжгүй, өмч хөрөнгөтэй холбоотой баримт материалууд архивд авагдаагүй нөхцөл байдлын улмаас аудитын нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байлаа.



Үндсэн мэдээлэл

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавих, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд компанийн засаглал, өмчийн төлөөлөл, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь зүйл заалтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.


Дүрслэл-1



Архангай аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит 176 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулсны 167 нь төсөвт байгууллага, 9 нь орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байна.

Дүрслэл 1

Орон нутгийн өмчийн 176 байгууллагыг салбараар ангилан хөрөнгийг 2023, 2024 оны байдлаар хөрөнгийн өөрчлөлтийг графикаар харуулбал боловсролын болон төрийн захиргааны байгууллагад хамгийн их хөрөнгө бүртгэлтэй байна. Спорт, соёл урлагийн салбарын хөрөнгө 20.5 хувиар, эрүүл мэндийн салбарын хөрөнгө 87.6 хувиар, ОНӨААТҮГ нь 177.2 хувиар нэмэгдсэн бол Аймаг сумын ЗДТГ болон ИТХ-ын хөрөнгө 9.1 хувиар буюу 9,107.7 сая төгрөгөөр буурсан байна.



Үүнээс аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн 2024 оны аудитлагдсан тайланд эрүүл мэндийн салбарын 19, соёлын салбарын 23, боловсролын салбарын 66 нийт 108 байгууллагуудын 95,665.6 сая төгрөгийн



хөрөнгүүд нэгтгэгдээгүй байна. Энэ нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагууд санхүүгийн тайланг салбарын ТЕЗ-д нэгтгүүлдэг болсонтой холбоотой байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 68 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба тэдгээрт 203,950.78 сая төгрөгийн анхны өртөгтэй 47,011.90 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.



Үндсэн хөрөнгийн 34.8 хувь буюу 54,554.8 сая төгрөгийг барилга байгууламж, 6.6 хувь буюу 10,345.3 сая төгрөгийг тээврийн хэрэгсэл, 5.8 хувь буюу 9,167.4 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, 1.3 хувь буюу 2,108.3 сая төгрөгийг тавилга эд хогшил, 11.6 хувь буюу 18,255.2 сая төгрөгийг зам гүүр барилга байгууламж, 0.2 буюу 425.5

сая төгрөгийг батлан хамгаалах болон түүх дурсгалт зүйл, 1.4 хувь буюу 1,913.3 сая төгрөгийг дуусаагүй барилга, 0.1 хувь буюу 230.9 сая төгрөгийг ном, 38.2 хувь буюу 59,938.1 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө эзэлж байна. /Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн аудитын тайлангаас авав /

Аудитын тайланг дэд зорилтоор бүлэг болгон танилцуулж байна.

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА****А.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлээгүй байна**

А.1.1. Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн дүн 2023 онд 109,086.2 сая төгрөг байсан бол 2024 онд 115,695.4 сая төгрөг болж өмнөхөөс 6.1 хувиар өссөн байна. /Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэлийн систем/

Аймгийн ОНӨГ-т орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд нэн шаардлагатай хэрэгцээтэй байгаа хөрөнгийн талаар нэгтгэсэн тоон мэдээлэл, тооцоо судалгаа байхгүй, ашиглаж байгаа программ нь хөрөнгийн мэдээллийг дансны төрөл, байршил, үйл ажиллагааны салбар зэрэг үзүүлэлтээр боловсруулдаггүй байна. Энэ нь сум, байгууллагын хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хөрөнгийг хуваарилахтай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

Хүснэгт-2 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өөрчлөлт /2023, 2024 он/

/сая төгрөг/

Д/Д	Аймаг, сумын нэр	2023 он	2024 он	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1	Ихтамир	4,075.44	4,360.20	284.76	6.99
2	Чулуут	2,261.06	2,643.29	382.23	16.90
3	Хангай	2,617.44	2,712.61	95.17	3.64
4	Тариат	3,137.80	3,321.91	184.11	5.87
5	Өндөр-Улаан	2,045.57	2,024.24	-21.33	- 1.04
6	Эрдэнэмандал	11,118.54	11,376.25	257.71	2.32
7	Жаргалант	1,593.90	2,965.25	1,371.35	86.04
8	Цэцэрлэг	2,068.36	2,025.49	-42.87	- 2.07
9	Хайрхан	2,768.37	3,115.29	346.92	12.53
10	Батцэнгэл	2,531.39	3,088.28	556.89	22.00
11	Өлзийт	2,090.04	2,772.45	682.41	32.65
12	Өгийнуур	1,489.76	1,596.37	106.61	7.16
13	Хашаат	1,632.42	2,106.61	474.19	29.05
14	Хотонт	2,392.23	2,582.01	189.78	7.93
15	Цэнхэр	3,362.41	3,634.09	271.68	8.08
16	Төвшрүүлэх	7,466.04	7,549.61	83.57	1.12
17	Булган	1,322.01	2,031.56	709.55	53.67
18	Эрдэнэбулган	16,260.64	15,908.16	-352.48	- 2.17
19	Цахир	2,153.52	2,197.32	43.80	2.03
20	Аймгийн ТЕЗ	36,699.24	37,684.42	985.18	2.68
Нийт дүн		109,086.18	115,695.41	6,609.23	6.06

Хүснэгтээс харахад өмнөх оноос Жаргалант сум 86 хувь, Булган сум 54 хувь, Өлзийт сум 33 хувь, Хашаат сум 29 хувиар хөрөнгө нэмэгдсэн нь хамгийн их бөгөөд бусад суманд 1-17 хувиар нэмэгджээ. Харин Өндөр-Улаан, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумын хөрөнгө өмнөх оноос 1-2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



А.1.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 6,567.7 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр олж авах саналыг аймгийн ОНӨГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2023-2024 онд нийт 111,043.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр дансанд бүртгэсэн ба өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-4. 2023-2024 онд шинээр нэмэгдсэн хөрөнгийг үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

Он	Боловсрол	Аймаг сумын ЗДТГ, ИТХ	ОНӨААТҮГ	Эрүүл мэнд	Спорт, соёл урлаг	Нийт нэмэгдсэн хөрөнгө
2023	15,882.4	9,841.3	8.5	4,812.3	2,103.7	32,648.2
2024	8,788.3	32,096.1	27.3	34,380.3	3,103.7	78,395.7
Нийт	24,670.7	44,041.1	35.8	39,192.6	3,103.7	111,043.9

/сая.төгрөг/

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Шинээр бүртгэсэн хөрөнгийг эх үүсвэрээр авч үзвэл 2023 онд нийт 32,648.2 сая төгрөгөөр нэмэгдсэний 3,036.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогоос, 1,234.1 сая төгрөг балансаас баланст авсан, 246.9 сая төгрөг нь дахин үнэлсэн, 28,131.0 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалт болон хандиваар үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Орон нутгийн өмч 2024 онд нийт 78,395.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсөвт байгууллагын өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогоос 5,176.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, балансаас баланст 19,777.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж авсан, хөрөнгийг дахин үнэлж өртгийг 196.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар нийт 53,244.9 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-5. Сүүлийн 2 жилд шинээр нэмэгдсэн хөрөнгийг эх үүсвэрээр нь авч үзвэл

Он	Нэмэгдсэн хөрөнгө	Эх үүсвэр			
		Өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогоос	Балансаас балансад шилжүүлсэн	Дахин үнэлсэн	Бусад
2023	32,648.2	3,036.2	1,234.1	246.9	28,131.0
2024	78,395.7	5,176.9	19,777.9	196.0	53,244.9
Нийт	111,043.9	8,213.1	21,012.0	442.9	81,375.9

/сая.төгрөг/

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Дүрслэл 2.

Аймгийн ОНӨГ-аас 2023 онд 2,582.5 сая төгрөгийн, 2024 онд 3,985.2 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч шинээр бэлтгэх зөвшөөрөл олгосон байна. Аймгийн ИТХ-аас орон нутгийн өмчийг хувьчлах, хөрөнгийг бүртгэлээс хасаж сэлбэгээр ашиглах, дуудлагын худалдаагаар худалдах, шилжүүлэх, актлахтай холбоотой 2023 онд 11, 2024 онд 15-н тогтоолыг баталжээ.



**Аудитын илрүүлэлт:**

- ✓ Эрдэнэбулган сумын "Ар манал", "Ар мөнгөн чагнуур", "Ар мөнхжин" ӨЭМТ-үүд нь аймгийн ОНӨГ-ын зөвшөөрөлгүйгээр 2023, 2024 онд төсвийн хөрөнгөөр эд хөрөнгө олж бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 1.10, 2.1² дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаас зөвшөөрөлгүйгээр хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, хууль, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллах албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв.

А.1.3 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь 2023-2024 онд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай 80.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ-ууд нь 2023 онд 8,866.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй, 2024 онд 15,715.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 24,581.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл бүртгэлтэй байна. Үүнд "Ар ус ундарга" ХХК-д 17,588.6 сая төгрөгийн цэвэрлэх байгууламжийг Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн авч бүртгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

ОНӨААТҮГ нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2023 онд 53.0 сая төгрөг, 2024 онд 27.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлжээ.

Хүснэгт-6. ОНӨААТҮГ-уудын хөрөнгө оруулалтын жагсаалт

ДД	Байгууллагын нэр	2023 он	2024 он	2023 он		2024 он	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	"Ар ус ундарга" ХХК	4,639.11	20,336.13			10.60	10.60
2	"Архангай орон сууц корпораци" ОНӨААТҮГ	0.92	0.79				
3	"Цөм сүрэг үржлийн төв" ААТҮГ	115.00	114.77				
4	"Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ	2,782.23	2,724.59	8.50	8.50	1.10	1.10
5	"Чулуут ахуй үйлчилгээ" ОНӨААТҮГ	1,086.16	1,062.92				
6	"Эрдэнэмандал хөгжил дэд бүтэц" ОНӨААТҮГ	155.66	263.78			15.00	15.00
7	"Хайрхан хөгжилийн дэд бүтэц" ОНӨААТҮГ	87.56	78.70	44.50	44.50	0.50	0.50
	Нийт дүн	8,866.6	24,581.7	53.00	53.00	27.20	27.20

² 2.1-т "Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь батлагдсан төсвийн эх үүсвэр болон ажлын зайлшгүй шаардлагаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй эд хөрөнгийг худалдан авах тухай саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна"

**Аудитын илрүүлэлт:**

- ✓ “Цэцэрлэг хотын хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ нь 2025 оны 06 сарын байдлаар байгууллагын 2025 оны бизнес төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг дарга болон Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй нь аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Цэцэрлэг хотын хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.7.1, аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын 6.2.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас ОНӨААТҮГ-уудын тухайн жилийн бизнес төлөвлөгөөг өмнөх онд нь багтааж боловсруулж батлуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.1.4 Аймгийн ОНӨГ нь хөрөнгө оруулалтын саналд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлсэн нэгдсэн судалгаагүй байна

Аймгийн ОНӨГ нь тухайн жилийн улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тооцоо судалгаа хийдэггүйгээс хөрөнгө оруулалт оновчтой бус хуваарилагдах эрсдэлтэй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалт, тооцооллыг бэлтгэж аймгийн ОНӨГ-т нэгтгүүлээгүй нь “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2³ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлж үнэлж байх зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.2 Аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагын 95 хувь нь хуульд заасан хугацаанд тооллогыг зохион байгуулсан ч 355.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна

А.2.1. Аудитын түүвэрт хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 95 хувь нь эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулсан байна

Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит 176 хуулийн этгээд нь 2023 онд 263,677.3 сая төгрөгийн, 2024 онд 299,616.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Хүснэгт-3 Хөрөнгийн хэмжээг үйл ажиллагааны салбараар авч үзвэл

Он	Боловсрол	Аймаг сумын ЗДТГ, ИТХ	Эрүүл мэнд	Спорт, соёл урлаг	ОНӨААТҮГ	Нийт хөрөнгө /сая төгрөг/
2023	106,773.20	100,219.70	28,754.90	19,062.90	8,866.60	263,677.30
2024	108,668.90	91,112.10	53,944.90	21,308.80	24,581.70	299,616.40
Нийт дүн	215,442.10	191,331.80	82,699.80	40,371.70	33,448.30	563,293.70

³ “... өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараагийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг бэлтгэн саналаа жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор ОНӨГ-т хүргүүлнэ”



Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 81 байгууллагыг түүвэрлэн эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулж үр дүнг тооцдог эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд 77 байгууллага нь эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулсан, 4 байгууллага эд хөрөнгийн тооллогыг огт зохион байгуулаагүй байна.

Аудитын явцад 31 байгууллага барилга болон авто тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй, баяжилт хийгээгүй зөрчил ажиглагдлаа.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Жаргалант сумын ЗДТГ, Эрдэнэмандал сумын ЭМТ, аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Ар манал” ӨЭМТ нь 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2⁴, 72 дугаар зүйлийн 72.4⁵, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1⁶ дэх заалтыг зөрчсөн байна.
- ✓ Хяналтын тооллогын явцад 31 байгууллагад 8,845.9 сая төгрөгийн үнэтэй барилга болон авто тээврийн хэрэгсэлд хувийн хэрэг үүсгээгүй, техникийн паспорт баяжилт хийгээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁷, БХБС-ын 2016 оны 180 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам-ын 2.1⁸ дэх заалтыг зөрчсөн байна. /Байгууллагын жагсаалтыг тайлангийн хавсралт 1-т дэлгэрэнгүй оруулав/

1. Алдаа зөрчлийг таслан зогсоож, хуулийн хэрэгжилтийг ханган эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр арга хэмжээг авч ажиллах;
2. Барилга, авто тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэргийг хөтлөх, ашиглалтын хугацаанд тогтмол баяжилт хийх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.2.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шинээр бий болсон 5-н нэр төрлийн 355.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, 32.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд ангилал зөрүүтэй бүртгэсэн байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 2023 онд 32,648.2 сая төгрөгийн, 2024 онд 78,395.7 сая төгрөгийн нийт 111,043.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр дансанд бүртгэж тайлагнажээ.

Орон нутгийн өмчит 81 хуулийн этгээдийг түүвэрт хамруулан 2024 оны жилийн эцсийн 25,908.7 сая төгрөгийн хөрөнгөд хяналтын тооллого хийж, шинээр бүртгэсэн хөрөнгийг тухайн онуудад орон нутгийн өмчид шинээр бүртгэх тогтоол, шийдвэрийн дүнтэй тулган шалгалаа.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аудитаар “Цэцэрлэг хотын хот тохижилт” ОНӨААТҮГ нь 4 машины авто граш, Батцэнгэл сумын ЕБС нь хүүхдийн автобус, Өлзийт сумын ЭМТ нь туслах барилга, Эрдэнэбулган сумын ЗДТГ нь 14.1 сая төгрөгийн анхны үнэтэй Тоёота Ландкрузер-105 маркийн тээврийн хэрэгсэл, 341.6 сая төгрөгийн өртөгтэй мал нядалгааны цехийн барилгыг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгээгүй

⁴ Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.

⁵ Тооллогын комисс дараахь үүрэгтэй:

⁶ 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;

⁷ 5.1.4.үнэн зөв байх

⁸ Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийг ашиглалтад орох үед түүний хувийн хэргийг нээж хөтлөн эдэлгээний хугацаанд түүнд өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг, шалгалт хийсэн, зориулалтыг өөрчилсөн, эвдрэл, гэмтэл, согог гарсан, сервитут тогтоосон, буулгасан тохиолдолд хувийн хэрэгт баяжуулалт хийнэ.



байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2¹⁰, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалттай нийцэхгүй байна.

- ✓ Орон нутгийн өмчит 10 хуулийн этгээд нь 32.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд ангиллыг зөрүүлж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹¹ дэх заалттай нийцэхгүй байна. /Тайлангийн хавсралт 2-оос дэлгэрэнгүй танилцана уу/

Аудитаас дараах шийдвэрийг хүргүүлэв. Үүнд:

1. Цаашид алдаа зөрчлийг таслан зогсоож хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллах;
2. Тайлангийн хавсралтад дурьдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зөрчилтэй асуудлыг таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.3 Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлах доод үнийг үндэслэлтэй тогтоогоогүй, дуудлага худалдааны талаар олон нийтэд цахимаар мэдээлээгүй байна.

А.3.1 Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлах дуудлагын худалдааны доод үнийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн тогтоогоогүй байна. Архангай аймгийн ТЕЗ-ийн хэмжээнд 2023-2024 онд 86 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж 55 нэр төрлийн хөрөнгийг борлуулж, 150,707.0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Харин 2023-2024 онд 19 тээврийн хэрэгсэл, 12 үл хөдлөх хөрөнгийн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй гэсэн шалтгаанаар амжилтгүй болсон байна. Хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт 7. Дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн тоо, төвлөрүүлсэн дүн /2023, 2024 он/
/мянган төгрөг/

Он	Дуудлага худалдаагаар худалдах шийдвэр	Үндсэн хөрөнгийн төрөл	Тоо, ширхэг	Доод үнэ	Дуудлага худалдаагаар зарагдсан		Хувьчлаагүй хөрөнгийн тоо	Шалтгаан, тайлбар
					Хөрөнгийн /тоо.ш/	Төвлөрүүлсэн мөнгөн дүн		
2023	Аймгийн ИТХ-ын 2023.12.01-ны өдрийн 13 дугаар тогтоол	Үл хөдлөх хөрөнгө	12	300.0-6,548.6	7	28,472.0	5	Оролцогч оролцоогүй
2024	Аймгийн ИТХ-ын 2024.09.12-ны өдрийн 18 дугаар тогтоол	Үл хөдлөх хөрөнгө	9	100.0-8,400.0	2	5,355.00	7	
2023	Аймгийн ИТХ-ын 2023.06.27-ны өдрийн 13 дугаар тогтоол	Тээврийн хэрэгсэл	31	100.0-4,500.0	24	40,450.00	7	
2024	Аймгийн ИТХ-ын 2024.09.12-ны өдрийн 18 дугаар тогтоол	Тээврийн хэрэгсэл	34	100.0-16,100.0	22	76,430.00	12	
Нийт			86	-	55	150,707.00	31	

Аймгийн хэмжээнд дуудлагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох батлагдсан аргачлалгүй байна. Сангийн Сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Төрийн өмчийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” журмын 6.3-д

⁹ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

¹⁰ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

¹¹ үнэн зөв байх;



дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийн шалгуур үзүүлэлтийн баталсан. Харин аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-д ямар шалгуур үзүүлэлтээр хөрөнгийн үнэлгээг хэрхэн тогтоож дуудлага худалдаагаар худалдан борлуулах тухай нарийвчлан тусгаагүй зөвхөн бүрдүүлэх бичиг баримтыг тусгасан байна.

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоохдоо сум, байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөл нь үлдэх өртөг болон хөрөнгийн чанарыг харгалзан саналаа аймгийн ОНӨГ-т ирүүлсний дагуу аймгийн ИТХ-д оруулж худалдах үнийг батлуулжээ.

Харин аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-д хувьчлах хөрөнгийн доод үнийг тогтоох аргачлалыг тусгасан бөгөөд 2025 оноос мөрдөж байна.

А.3.2 Дуудлага худалдааны мэдээллийг хэвлэлд мэдээлдэг хэдий ч цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд ил тод түгээгээгүй байна

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувьчлах, тээврийн хэрэгслийг худалдан борлуулахтай холбоотой 86 хөрөнгийн зарын мэдээллийг “Өдрийн сонин”, “Архангайн амьдрал” сонинд 2023-2024 онуудад 18 удаа нийтэлсэн байна.

Харин аймгийн ОНӨГ нь Худалдан авах ажиллагааны газартай нэг цахим хуудастай байсан тул дуудлагын худалдааны мэдээллийг бүрэн оруулаагүй, 2024 оноос тусдаа үйл ажиллагаа явуулж эхэлсэн хэдий ч албан ёсны веб сайтгүй, мөн 2022 оноос пэйж хуудсандаа дуудлагын худалдаа болон бусад мэдээ, мэдээллийг оруулаагүй, шинэчлэл хийгээгүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12¹²-д заасантай нийцэхгүй байна.

Аудитаас орон нутгийн өмчийг дуудлага худалдаагаар хувьчлах, худалдан борлуулахтай холбоотой мэдээ мэдээллийг албан ёсны веб сайт болон пэйж хуудсаар дамжуулан иргэдэд шуурхай ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээ авч, үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.3.3 Орон нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн хувьчлах доод үнийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын үнэлгээнд үндэслэн тогтоохгүйгээр худалдан борлуулсан байна

Аймгийн хэмжээнд 2023, 2024 онд нийт 86 хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийг тогтоож, дуудлагын худалдаагаар 150.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Дээрх хөрөнгүүдийг хувьчлах доод үнийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын үнэлгээнд үндэслэн тогтоохгүйгээр худалдсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 3¹³, Төрийн

¹² 37.1.12-т “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, ... хүргэх”

¹³ Төсөвт байгууллагын дансанд бүртгэлтэй, төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдаанаас олсон орлогоос тухайн дуудлагын худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардал (хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн бол үнэлгээний төлбөр, дуудлагын худалдааны зар мэдээ байршуулахад төлсөн төлбөр)-ыг хассан дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсугай.



болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5¹⁴ дахь заалтыг зөрчсөн байна. Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ хийлгээгүйгээс тухайн хөрөнгийг бодитой бус үнэлэх, бусдад давуу тал олгох, ашиг сонирхол үүсэх үр дагавартай байна.

Аудитаас орон нутгийн өмч хөрөнгийг дуудлага худалдаагаар хувьчлах үл хөдлөх хөрөнгүүдэд эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.4 Орон нутгийн өмчийн хөрөнгийг актлах, данснаас хасах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

А.4.1 Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2023-2024 онд нийт 38,535.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан ба үүнээс 9,364.4 сая төгрөгийн хөрөнгийг ОНӨГ-ын зөвшөөрлийн дагуу акталж устгасан байна. Хасагдсан хөрөнгийн мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-8. Нийт хасагдсан хөрөнгийн жагсаалт

Он	Хасагдсан хөрөнгө	Эх үүсвэр			
		Акталсан	Балансаас балансад шилжүүлсэн	Худалдсан	Бусад
2023	6,294.1	4,461.5	945.1	69.2	818.3
2024	32,241.7	4,902.9	25,596.0	25.9	1,716.9
Нийт	38,535.9	9,364.4	26,541.2	95.0	2,535.3

/сая.төгрөг/

Аудитын илрүүлэлт:


Аудитаар “Цэцэрлэг хотын хот тохижилт” ОНӨААТҮГ-ын удирдлага нь албан тушаалаа урвуулан ашиглаж байгууллагын эзэмшлийн газарт хувийн хэвшлийн уурын зуухны барилга бариулж, өөрийн байгууллагын уурын зуухны хэсгийг зөвшөөрөлгүй ашиглуулж, төсвийн хөрөнгийг үрэгдүүлсэн зөрчил илэрлээ.

Аудитаас дээрх зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах санал бүхий албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.4.2 Түүвэрт хамрагдсан байгууллагын 97.5 хувь нь хөрөнгийг акталж, устгах ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор гүйцэтгэсэн байна.

Дүрслэл 4.

Аудитаар түүвэрт хамрагдсан 81 байгууллагын 656 албан хаагчдаас “Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг актлахдаа өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор гүйцэтгэж байна уу” гэсэн асуултын хүрээнд санал асуулга авахад 90 хувь буюу 592 тийм, 7 хувь буюу 49 үгүй гэсэн санал өгсөн бол 3 хувь буюу 20 санал асуулгад хариулаагүй байна. Санал асуулгын дүнг нэгтгэж



72.4.5-д¹⁴ “... эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгөд үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих...”



үзвэл байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг актлахдаа ӨХЗ-ийн хяналт дор устгасан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Аудитаар Батцэнгэл сумын Соёлын төвийн өмч хамгаалах зөвлөлийн гишүүд нь 2023 онд 6,180.0 мянган төгрөгийн үнэтэй хөрөнгийг, мөн сумын ЭМТ-ийн өмч хамгаалах зөвлөл нь 2024 онд 68,972.5 мянган төгрөгийн үнэтэй хөрөнгийг устгахдаа устгалын акт үйлдэж, фото зургаар баримтжуулаагүй нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 8.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлөөр данснаас хасах шийдвэрийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулж фото зургаар баримтжуулан үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

А.4.3 Орон нутгийн өмчийн 9,364.4 сая төгрөгийн хөрөнгө акталсныг мэдээллийн системд бүртгэж, хөрөнгийн бүртгэлээс хасаж тайлагнасан байна

Аймгийн ОНӨГ-т 2023 онд 77 байгууллагын 4,461.5 сая төгрөгийн хөрөнгө, 2024 онд 91 байгууллагын 4,902.9 мянган төгрөгийн хөрөнгө нийт 9,364.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассаныг орон нутгийн өмчийн мэдээллийн системд бүрэн бүртгэсэн байна. Энэ нь хөрөнгийг данснаас хасах тухай эрх байгууллагуудын шийдвэр, аймгийн ОНӨГ-аас олгосон зөвшөөрөлтэй нийцэж байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Б.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, ашиглалтад хяналт тавьж ажиллаагүй байна

Б.1.1 Орон нутгийн өмчид бүртгэлтэй мал, амьтадыг түрээсээр ашиглуулах заавар аргачлалгүйгээс түрээсийн төлбөр 171 толгой малыг хүлээн аваагүй, орон нутгийн өмчид бүртгээгүй байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дулааны шугам сүлжээ, орон сууц, комбайныг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 31 дүгээр тогтоолын дагуу түрээсийн гэрээ байгуулан бусдад ашиглуулж байна.

Харин орон нутгийн өмчид 1,285.8 сая төгрөгөөр бүртгэсэн 800 толгой эм хонь, 16 толгой хуц, 88 толгой тугалтай үнээ, 175 толгой гунж, 17 толгой бух нийт 1096 толгой малыг түрээсийн гэрээгээр бусдад ашиглуулж байгаа боловч энэ талаар нарийвчлан зохицуулсан эрх бүхий байгууллагаас баталсан заавар, аргачлалгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Орон нутгийн өмчид бүртгэлтэй 816 хонийг түрээсээр ашиглуулсны төлбөрт 2023 онд 46, 2024 онд 125, нийт 171 толгой хонийг ашиглагч нараас хүлээн авахаар байтал 2025 оны эхний хагас жилийн байдлаар огт хүлээн аваагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, аймгийн ОНӨГ болон ХХААГ-аас гэрээнд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүйгээс мал дутагдах, шамшигдах эрсдэлийг үүсгэсэн байна.



- ✓ Батцэнгэл сумын ЗДТГ нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 181.2 сая төгрөгийн өртөгтэй халууны усны барилгыг гэрээ байгуулахгүйгээр бусдад ашиглуулсан бөгөөд сумын төсөвт орлого төвлөрүүлээгүй байна. Энэ нь МУЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 1.3¹⁵, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 6.2¹⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас дараах шийдвэрийг хүргүүлэв. Үүнд:

1. Түрээсийн гэрээнд заасны дагуу түрээсийн төлбөр болох 171 толгой хонийг ашиглагч нараас хүлээн авч хувийн хэрэг үүсгэн орон нутгийн өмчид бүртгэх, бүх түрээслэгч нартай байгуулсан гэрээг жил бүр дүгнэх, үржүүлэг, технологийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах
2. Орон нутгийн өмчид бүртгэлтэй мал түрээслэх, бүртгэх тайлагнах, хяналт тавихтай холбоотой заавар, аргачлалыг боловсруулж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулах
3. Батцэнгэл сумын Халуун усны барилгыг ашиглагчтай гэрээ байгуулж, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв.

Б.1.2 Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг түрээслүүлсэн төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна

Орон нутгийн өмчийн газрын хөрөнгөд бүртгэлтэй дараах хөрөнгүүдийг түрээсийн гэрээгээр 2023-2024 онд ашиглуулсны төлбөрт нийт 74.6 сая төгрөгийг орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 57.4 сая төгрөг буюу 76.9 хувийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгийн 2023, 2024 оны төвлөрүүлэлтийн байдал /мянган төгрөг/

Түрээсэлж буй хөрөнгө	2023 он			2024 он			Нийт дутуу төвлөрүүлсэн дүн /мянган төгрөгөөр/
	Гэрээний дагуу төлөх дүн	Төсөвт төвлөрүүлсэн дүн	Зөрүү	Гэрээний дагуу төлөх дүн	Төсөвт төвлөрүүлсэн дүн	Зөрүү	
Булган хангай хорооллын шугам сүлжээ	8,200.0	8,200.0	-	16,400.0	-	16,400.0	16,400.0
Тариат сумын шугам сүлжээ	6,000.0	6,000.0	-	12,000.0	12,000.0	-	-
Орон сууц -6ш	775.2	775.2	-	775.2	624.4	150.8	150.8
FOTON LOVOL маркийн комбайн	16,000.0	9,309.0	6,691.0	14,400.0	21,091.0	- 6,691.0	-
Нийт дүн	30,975.2	24,284.2	6,691.0	43,575.2	33,091.0	10,484.2	16,550.8

Түрээсийн гэрээний дагуу 2024 онд төвлөрүүлбэл зохих 16.6 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна. Үүнд:

¹⁵ 1.3-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ"

¹⁶ 6.2-т "Барилгын 1м2 талбайн түрээсийн төлбөрт аймагт 8000-20000, суманд 3000-10000 төгрөг байна. Үл хөдлөхөөс бусад хөрөнгийг 2 тал гэрээгээр тохиролцон шийдвэрлэнэ"

**Аудитын илрүүлэлт:**

- ✓ Булган хангай хорооллын шугам сүлжээ ашиглуулах гэрээг "Эх голомт илч" ХХК-тай байгуулаагүйгээс 16.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.
- ✓ Орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууцны түрээсийн төлбөрийг гэрээний дагуу хагас жил тутам тооцож аваагүйгээс 0.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.

Аудитаас дээрх төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Б.1.3 Түрээсээр бусдад ашиглуулж байгаа орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, чанарт хяналт шалгалт хийгээгүй байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2023, 2024 онд түрээсийн гэрээгээр ашиглуулсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, чанарын байдалд хяналт шалгалтыг хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4¹⁷ дэх хэсэгт заасныг зөрчсөн байна. (Эх сурвалж: Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025.06.04-ны өдрийн 81 дүгээр албан бичиг, аймгийн ОНӨГ-ын 2025.06.03-ны өдрийн 177 дугаар албан бичиг)

Аудитаас аймгийн орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулалтын байдалд жил бүр хяналт шалгалтыг зохион байгуулж үр дүнг аймгийн ИТХ-д тайлагнаж, шийдвэрлүүлэн холбогдох арга хэмжээг ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.2 Орон нутгийн эд хөрөнгийн тооллогын дүн нэгтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлээгүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна.**Б.2.1 Дутагдалтай болон ашиглалтгүй хөрөнгийн судалгаа гаргаагүй, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна**

Аймгийн ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс ашиглалтгүй болон дутагдалтай байгаа хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй судалгаа гаргуулан аваагүй, хяналт, дүн шинжилгээ хийгээгүй байна. (Эх сурвалж: аймгийн ОНӨГ-ын 2025.06.03-ны өдрийн 177 дугаар албан бичиг)

Б.2.2 Аймгийн хэмжээнд орон нутгийн эд хөрөнгийн тооллогын дүн, нэгтгэлийг 2022 оноос хойш аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулаагүй байна

Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн "Улсын үзлэгийн тооллого"-ыг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/301 дугаар захирамжийн дагуу зохион байгуулж, орон нутгийн өмчит 172 байгууллагын хамруулжээ.

¹⁷ 78.4-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах"



“Улсын үзлэгийн тооллого 2022”-ын дүнгээр 74.0 сая төгрөгийн 21 нэр төрлийн 72 ширхэг хөрөнгө дутагдсан, 2 нэр төрлийн 150 ширхэг хөрөнгө бүртгэлд тусгаагүй, 813.2 сая төгрөгийн 34 ширхэг хөрөнгийг маргаантай гэж илрүүлжээ.

Энэхүү үзлэг тооллогыг дүнг аймгийн ИТХ-ын 2022.11.30-ны 24 дүгээр тогтоолоор баталгаажуулсан бөгөөд тогтоолын 2-д заасан “улсын үзлэгээр илэрсэн дутагдуулсан хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, бүртгэл тусгаагүй хөрөнгийг бүртгэлжүүлэх, ашиглалтгүй хөрөнгийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж хэлэлцүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлээгүй, аймгийн ИТХ-д эргэж тайлагнаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2¹⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас аймгийн ИТХ-ын 2022 оны 24 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж үр ашгийн тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.2.3 Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2023-2024 онд орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцээгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1¹⁹, 77.2.2²⁰-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг, сумын Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлсэн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт чиглэл өгөх, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулахаар заасан.

Гэтэл аймгийн ИТХ-аас 2023, 2024 онд орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, хөрөнгийн асуудалтай холбоотой тайлан, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцээгүй байна. (Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 60 дугаар албан бичиг)

Аудитаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.2.2-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулах, өмч хөрөнгөтэй холбоотой тайлан, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцэж дүгнэлт, чиглэл өгч ажиллах талаар аймгийн ИТХ-ын даргад зөвлөмж хүргүүлэв.

Б.3 Орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлээгүй, 427.4 сая төгрөгийн хөрөнгийг дутагдуулсан байна

Б.3.1 Аудитаар түүвэрт хамрагдсан 81 байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөө тайлан, тооллогын дүн өгсөн шийдвэрийг хянахад

¹⁸ 77.2.2-т “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”

¹⁹ 77.2.1-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”



хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, чанар байдлыг үнэн зөв тодорхойлоогүй, зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлээгүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зөвлөмж чиглэл өгөөгүй зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

✓ Орон нутгийн өмчит нийт 6 хуулийн этгээд нь өмч хамгаалах зөвлөлийг байгуулаагүй, ажлын төлөвлөгөө, тайлангүй, 14 байгууллага нь 2023, 2024 оны төлөвлөгөө, тайлан, нотлох баримт материалыг архивын нэгж үүсгэж хадгалаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.1.1, 7.1, 7.2, 7.3 дах заалтыг тус тус зөрчсөн байна. /Тайлангийн хавсралт 3-аас байгууллагуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү/

Аудитаас аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн захирамжаар баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангуулж, орон нутгийн өмчит хуулийн этгүүдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг тооцорж ажиллах ОНӨГ-т албан шаардлагыг хүргүүлэв.

Б.3.2 Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн эд хөрөнгө 2023, 2024 оны байдлаар байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртөөгүй байна. (Эх сурвалж: Аймгийн Онцгой байдлын газрын 2025.06.20-ны өдрийн 28/219 дугаар албан бичиг)

Б.3.3. Орон нутгийн өмч хөрөнгийг дутагдуулсан, гэмтээсэн этгээдээр нөхөн төлүүлэх, хохиролгүй болгох, холбогдох албан хаагчид хариуцлага тооцохтой холбоотой шийдвэр гараагүй байна. (Эх сурвалж: аймгийн ОНӨГ-ын 2025.06.03-ны өдрийн 177 дугаар албан бичиг)

Гэтэл аудитын явцад түүвэрлэн хяналтын тооллого хийсэн байгууллагууд дээр 427.4 сая төгрөгийн хөрөнгө дутагдуулсан зөрчил илэрлээ. Энэ нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад ОНӨГ-аас тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. (Тайлангийн хавсралтаар байгууллага тус бүрээр дутагдуулсан, бүртгэлд тусгаагүй хөрөнгийн судалгаагаар оруулсантай танилцана уу)

Аудитаас орон нутгийн өмчид тавих хяналтыг сайжруулж, хөрөнгө дутагдуулсан төрийн байгууллага тус бүрээр асуудлыг тодорхойлж хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох, нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.3.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулсан ч бодитой дүгнэж холбогдох арга хэмжээ аваагүй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 715 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх аргачлал"-ын хүрээнд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчит 176 хуулийн этгээдтэй Өмч эзэмшлийн гэрээг байгуулжээ.



Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2024 оны 3 дугаар улиралд гэрээний хэрэгжилтийг дүгнэхэд бүрэн хангалттай /96-100/ үнэлэгдсэн 116, хангалттай /76-95/ үнэлэгдсэн 42, 8 байгууллага хангалтгүй /75-аас доош/ үнэлэгдсэн ба 10 байгууллага нь гэрээ дүгнэх явцад эзэнгүй, ээлжийн амралттай гэх шалтгаанаар дүгнүүлээгүй байна. Хангалтгүй үнэлэгдсэн байгууллагуудад ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгавар өгсөн боловч үүрэг даалгаврын хэрэгжилтийг дүгнээгүй байна. (Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан)

Аудитын илрүүлэлт:

✓ Орон нутгийн өмчит 176 хуулийн этгээдийн өмч эзэмшлийн гэрээг бодитой дүгнээгүй, үр дүнг нэгтгэж тайлагнаагүй, хангалтгүй үнэлэгдсэн холбогдох байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцоогүй, хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг нотлох баримтаар үнэлж, шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 715 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх аргачлал"-ыг зөрчсөн байна.

✓ Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын ЭМТ-д олгосон 8.5 сая төгрөг, Хайрхан сумын ЭМТ-д олгосон 11.4 сая төгрөг, Жаргалант сумын ЭМТ-д олгосон 11.4 сая төгрөг, нийт 31.5 сая төгрөгийн үнэтэй 11 мотоцикл болон аймгийн ОНӨГ-ын хөрөнгөд бүртгэлтэй Foton Lovol маркийн комбайныг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ, улсын дугаар аваагүй, техник ашиглалтын хувийн хэрэг үүсгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаас дараах шийдвэрийг хүргүүлэв. Үүнд:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдтэй ТӨБЗГ-ын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан гэрээ дүгнэх аргачлалын дагуу бодитой үнэлэх, үр дүнг тооцож аймгийн ИТХ болон Засаг даргад танилцуулж хэвших;
2. Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын асуудлаар байгууллагын удирдлага, санхүү болон Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг хамруулан аргазүйн сургалтыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах
3. Орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ, цэнхэр дэвсгэртэй улсын дугаарыг авах, техник ашиглалтын хувийн хэрэг үүсгэж, хөтлүүлэх арга хэмжээг авч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлээгүй байна
- ✓ Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулж, хөрөнгийг актлах, данснаас хасах үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлсэн байна
- ✓ Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлах дуудлага худалдааны доод үнийг мэргэжлийн байгууллагаар тогтоогоогүй, мэдээллийг цахимаар хүргээгүй байна
Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээсэлсний орлогын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, түрээслүүлж байгаа хөрөнгийн ашиглалтад хяналт тавиагүй байна
- ✓ Орон нутгийн өмчид бүртгэлтэй хонин сүргийг түрээсээр ашиглуулсны төлбөрт 171 толгой хонийг хүлээн аваагүй, орон нутгийн өмчид бүртгээгүй байна
- ✓ Орон нутгийн өмчид бүртгэлтэй мал сүргийг бусдад түрээслүүлэх, түрээсийн төлбөрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавих талаар зохицуулсан заавар аргачлалгүй байна.
- ✓ Орон нутгийн эд хөрөнгийн тооллогын дүн нэгтгэлийг жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна
- ✓ Орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлээгүй, 427.4 сая төгрөгийн хөрөнгө дутагдуулсан байна

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР НЬ ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭГ БОДИТОЙ ДҮГНЭДЭГГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 2,406.6 сая төгрөгийн 21 зөрчил илэрснээс 2,358.8 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 31.3 сая төгрөгийн зөрчилд 9 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

-----o0o-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА П.ГОМБОДОРЖИД

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.2.2-д заасан бүрэн эрхийн дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулах, өмч хөрөнгөтэй холбоотой тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж дүгнэлт гаргаж хэвшин аймгийн Засаг даргад чиглэл өгч ажиллах

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

1. Аймгийн ИТХ-ын 2022 оны 24 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж үр ашгийн тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх
2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар хувьчлах үл хөдлөх хөрөнгүүдэд эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгэх талаар “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах” журамд тусгаж батлуулах
3. Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын асуудлаар байгууллагын удирдлага, санхүү болон Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг хамруулан аргазүйн сургалтыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах
4. Аймгийн орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулалтын байдалд жил бүр хяналт шалгалтыг зохион байгуулж үр дүнг аймгийн ИТХ-д тайлагнаж, шийдвэрлүүлэн холбогдох арга хэмжээг ажиллах

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуягт

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлж үнэлж байх
2. ТӨБЗГ-ын 715 дугаар тогтоолоор баталсан гэрээ дүгнэх аргачлалын дагуу бодитой үнэлэх, үр дүнг тооцож аймгийн ИТХ болон Засаг даргад танилцуулж хэвших;
3. Орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ, цэнхэр дэвсгэртэй улсын дугаарыг авах, техник ашиглалтын хувийн хэрэг үүсгэж, хөтлүүлэх арга хэмжээг авах
4. Орон нутгийн өмчийг дуудлага худалдаагаар хувьчлах, худалдан борлуулахтай холбоотой мэдээ мэдээллийг албан ёсны веб сайт болон пэйж хуудсаар дамжуулан иргэдэд шуурхай ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсний дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025.07.25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас: 7033 3241, Факс: (976) 7033 3241,
Цахим шуудан: arkhangai.onug@gmail.com

2025.06.24 № 232
танай 2025.06.23-ны № 253 -т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл,
ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудитын тайлантай
танилцлаа.

Тайлантай холбоотой саналгүй болно.

ДАРГА



Х.ГАНХУЯГ

Анхуурч О.Ца-Архангай
2025.06.24/VI



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/29

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 28-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад (Б.Цэрэннадмид), Орон нутгийн өмчийн газрын дарга (Х.Ганхуяг)-т зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн /23/ тоот тушаалын хавсралт

Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж

Аудитын код: АРА-2025/32-ШТА-ГА

№	Хүргүүлсэн шийдвэрийн					Хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Тоо	Шийдвэр	Дугаар	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Эрдэнэбулган сумын "Ар манал", "Ар мөнгөн чагнуур", "Ар мөнхжин" ӨЭМТ-үүд нь аймгийн ОНӨГ-ын зөвшөөрөлгүйгээр төсвийн хөрөнгөөр шинээр үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн. Жаргалант сумын ЗДТГ, Эрдэнэмандал сумын ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, "Ар манал" ӨЭМТ нь эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулаагүй аудитад баримт материалыг хамруулаагүй тул эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээг авч ажиллах	-	1	Албан шаардлага	400	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
2	"Цэцэрлэг хотын хот тохижилт" болон "Тунгалаг тамир" ОНӨААТҮГ-үүд нь 2025 оны бизнес төлөвлөгөөг батлуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах	-	1	Албан шаардлага	401	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
3	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлж үнэлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлээгүй байх тул зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах	-	1	Зөвлөмж	112	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
4	Орон нутгийн өмчит 2, эрүүл мэндийн салбарын 4, боловсролын салбарын 2, соёлын салбарын 2 нийт 10 орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 32,778.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд ангилал зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах	32,778,000.00	1	Албан шаардлага	402	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
5	Аудитаар хийгдсэн хяналтын тооллогоор аймгийн ТЕЗ-ийн харьяа 1, Боловсролын салбарын 8, Соёлын салбарын 4, Эрүүл мэндийн салбарын 8, улсын төсвийн 2, орон нутгийн төсвийн 8 нийт 31 байгууллага нь 8,845.9 сая төгрөгийн үнэтэй барилга болон авто тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй зөрчлийг арилган барилга, авто тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэргийг хөтлөх, ашиглалтын хугацаанд тогтмол баяжилт хийх арга хэмжээ авч ажиллах	-	1	Албан шаардлага	403	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
6	"Цэцэрлэг хотын хот тохижилт" ОНӨААТҮГ 4 машины авто граш, Батцэнгэл сумын ЕБС 25 суудалтай хүүхдийн автобус, Өлзийт сумын ЭМТ-ийн туслах барилга, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 14,096.7 мянган төгрөгийн Тоёота Ландкрюзер-105 маркийн тээврийн хэрэгсэл мөн 341,618.2 мянган төгрөгийн өртөгтэй мал нядалгааны цехийн барилгыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилган хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллах	355,714,982.90	1	Албан шаардлага	404	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
7	Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дуудлагаар худалдах доод үнийг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлт үнэлгээний тайланд үндэслэн тогтоогоогүй байх тул холбогдох журамд нэмж тусган батлуулж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах	-	1	Зөвлөмж	113	Аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
8	Орон нутгийн өмчийг дуудлагаар худалдахтай холбоотой мэдээ мэдээллийг байгууллагын албан ёсны веб сайт болон пэйж хуудсаар дамжуулан иргэдэд шуурхай ил тод, нээлттэй мэдээллэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах арга хэмжээ авах	-	1	Зөвлөмж	114	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
9	"Цэцэрлэг хотын хот тохижилт" ОНӨААТҮГ-ын удирдлага нь албан тушаалаа урвуулан ашиглаж байгууллагын эзэмшлийн газарт хувийн хөшлийн уурын зуухны барилга бариулж, хуучин уурын зуухны янданг зөвшөөрөлгүй ашиглуулан, төсвийн хөрөнгийг шамшигдуулсан байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлэх арга хэмжээ авах	-	1	Хууль хяналтын байгууллага руу шилжүүлэн шалгуулах албан шаардлага	405	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
10	Батцэнгэл сумын Соёлын төв болон ЭМТ-ийн өмч хамгаалах байнгын зөвлөл нь 75,152.5 мянган төгрөгийн хөрөнгийг устгалын акт үйлдэж, фото зургаар баримтжуулаагүй данснаас хассан байх тул зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах	75,152,524.00	1	Албан шаардлага	406	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг



11	Батцэнгэл сумын ЗДТГ нь 181,858.1 мянган төгрөг өртөгтэй халууны усны барилгыг түрээсийн гэрээ байгуулахгүйгээр бусдад ашиглуулж байгаа бөгөөд орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлээгүй, Орон нутгийн өмчид бүртгэлтэй малыг гэрээгээр ашиглуулсны төлбөрт 2023 онд 46, 2024 онд 125, нийт 171 толгой мал хүлээн авч орон нутгийн өмчид бүртгээгүй, түрээсийн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, аймгийн ОНӨГ, ХХААГ-аас гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлээгүй байх тул зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах.	1,467,658,128.00	1	Албан шаардлага	407	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
12	Булган хангай хорооллын шугам сүлжээ ашиглуулах гэрээг "Эх голомтын илч" ХХК-тай байгуулаагүйтэй холбоотой 16,400 мянган төгрөг, орон сууцны түрээсийн орлого 150.2 мянган төгрөгийг гэрээний дагуу хагас жил тутам тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байх тул орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах.	16,550,200.00	1	Албан шаардлага	408	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
13	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнг баталсан аймгийн ИТХ-ын 2022.11.30-ны 24 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй улсын үзлэгээр илэрсэн дутагдуулсан хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, бүртгэл тусгаагүй хөрөнгийг бүртгэлжүүлэх, ашиглалтгүй хөрөнгийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж хэлэлцүүлэх арга хэмжээ аваагүй байна. Иймд тогтоолын хэрэгжилтийг хангаж үр дүнг ИТХ-д оруулж хэлэлцүүлэх арга хэмжээ авах.	-	1	Зөвлөмж	115	Аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
14	Орон нутгийн өмчит 6 хуулийн этгээд нь өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулаагүй, ажлын төлөвлөгөө, тайлангүй, 14 байгууллага нь 2023, 2024 оны өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан, холбогдох баримт материалыг архивын нэгж үүсгээгүй байх тул аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн захирамжаар баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах.	-	1	Албан шаардлага	409	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
15	Орон нутгийн өмчид бүртгэлтэй түрээсээр ашиглуулж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд жил бүр хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллаагүй байгаа тул түрээсээр ашиглуулж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд жил бүр хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.	-	1	Зөвлөмж	116	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
16	Аймгийн ИТХ-аас орон нутгийн өмч эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулаагүй, хөрөнгөтэй холбоотой тайлан, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцээгүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.2.2-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн хяналт шалгалтыг зохион байгуулж, өмч хөрөнгөтэй холбоотой нэгдсэн тайлан тооллогын дүнг хэлэлцэж дүгнэлт, чиглэлийг аймгийн Засаг даргад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах.	-	1	Зөвлөмж	117	Аймгийн ИТХ-ын дарга	П.Гомбодорж
17	Орон нутгийн өмчид аймгийн ОНӨГ-аас тавих хяналт алдагдсанаас 8,126.7 мянган төгрөгийн барилга, 419,320.7 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг дутагдуулж үрэгдүүлсэн байх бөгөөд цаашид хөрөнгө үрэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх тул хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хөрөнгө дутагдуулсан байгууллага тус бүрээр асуудлыг нарийвчлан тодорхойлж буруутай этгээдээр төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлэн шалгуулж хариуцлага тооцох, арга хэмжээ авах.	427,447,436.00	1	Албан шаардлага	410	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
18	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын ЭМТ-д олгосон 8,500 мянган төгрөг, Хайрхан сумын ЭМТ-д олгосон 11,400 мянган төгрөг, Жаргалант сумын ЭМТ-д олгосон 11,400 мянган төгрөгийн нийт 31,350.0 мянган төгрөгийн үнэтэй 11 мотоцикл, ОНӨГ-ын хөрөнгөд бүртгэлтэй Foton Lovol маркийн комбайныг улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ, улсын дугаар аваагүй, хувийн хэрэг үүсгээгүй, техник ашиглалтын паспортыг хөтлөөгүй зөрчлийг таслан зогсоож, арилгах арга хэмжээг авах.	31,350,000.00	1	Зөвлөмж	118	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
19	Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өмч эзэмшлийн гэрээг бодитой дүгнээгүй, үр дүнг нэгтгэж тайлагнаагүй, хангалтгүй үнэлэгдсэн байгууллагуудын удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нотлох баримтаар үнэлэх арга хэмжээ аваагүй байх тул зарчлийг таслан зогсоож гэрээг бодитой дүгнэж, үр дүнг тооцсон тайланг аймгийн ИТХ болон Засаг даргад танилцуулах арга хэмжээг авч ажиллах.	-	1	Зөвлөмж	119	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
Төлбөрийн акт		-	0				
Албан шаардлага		2,375,301,270.90	11.00				
Зөвлөмж		31,350,000.00	8				
НИЙТ ДҮН		2,406,651,270.90	19				



ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Тайлангийн хавсралт №1

Барилга болон авто тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй байгууллагын жагсаалт

Салбарын харьяалал	Төсөвт байгууллагын нэр	Аудитаар илэрсэн зөрчлийн товч утга, хууль, журмын заалт
Эрүүл мэнд	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 12 авто машины техникийн паспорт хувийн хэргийн баяжилт хийгээгүй
Эрүүл мэнд	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Орон нутаг	Цэцэрлэг хотын тохижилт ААНТҮГ	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга болон тээврийн хэрэгслүүдэд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
аймгийн ТЕЗ-ийн байгууллага	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Тээврийн хэрэгслийн техникийн паспорт хувийн хэрэгт баяжилт хийгээгүй
Орон нутаг	Батцэнгэл сумын ЗДТГ	Байгууллагын өмчид бүртгэлтэй 1,732,463,833.42 төгрөгийн анхны үнэтэй 10 барилгад хувийн хэрэг үүсгээгүй.
Орон нутаг	Батцэнгэл сумын ЗДТГ	Мөн байгууллагын өмчид бүртгэлтэй 7 авто машины техникийн паспортыг шинэчлээгүй
Боловсрол	Батцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэг	Байгууллагын өмчид бүртгэлтэй 3,163,006,292 төгрөгийн анхны үнэтэй 3 барилгад хувийн хэрэг үүсгээгүй.
Боловсрол	Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль	Байгууллагын өмчид бүртгэлтэй 987,805.425 төгрөгийн анхны үнэтэй 3 барилгад хувийн хэрэг үүсгээгүй.
Боловсрол	Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль	Хөрөнгөд бүртгэлтэй 29,300.000 төгрөгийн анхны үнэтэй пургон автомашинд техникийн паспорт хувийн хэргийг хөтлөөгүй
Соёл	Батцэнгэл сумын Соёлын төв	Байгууллагын өмчид бүртгэлтэй 831,124,637.92 төгрөгийн анхны үнэтэй 1 барилгад хувийн хэрэг үүсгээгүй.
Соёл	Батцэнгэл сумын Соёлын төв	Хөрөнгөд бүртгэлтэй 10,000,000 төгрөгийн анхны үнэтэй УА3469 автомашинд техникийн паспорт хувийн хэргийг хөтлөөгүй
Орон нутаг	Өлзийт сумын ЗДТГ	Байгууллагын өмчид бүртгэлтэй барилгуудад хувийн хэрэг үүсгээгүй.
Орон нутаг	Өлзийт сумын ЗДТГ	Мөн байгууллагын өмчид бүртгэлтэй авто машины техникийн паспортыг шинэчлээгүй
Соёл	Өлзийт сумын Соёлын төв	Шинэ барилгад хувийн хэрэг үүсгээгүй
Боловсрол	Өлзийт сумын ЕБС	Байгууллагын өмчид бүртгэлтэй барилгуудад хувийн хэрэг үүсгээгүй.
Эрүүл мэнд	Өлзийт ЭМТөв сумын	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 авто машинд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Орон нутаг	Хайрхан ЗДТГ сумын	Байгууллагын өмчид бүртгэлтэй 1,323,040,463.34 төгрөгийн анхны үнэтэй 8 барилгад хувийн хэрэг үүсгээгүй.



Орон нутаг	Хайрхан ЗДТГ	сумын	Мөн байгууллагын өмчид бүртгэлтэй 282,500,000 төгрөгийн анхны өртөгтэй 4 авто машинд техникийн паспортыг хөтлөөгүй
Боловсрол	Хайрхан ЕБС	сумын	Барилгын хувийн хэрэгт баяжилт хийгээгүй.
Эрүүл мэнд	Хайрхан ЭМТөв	сумын	Мөн байгууллагын өмчид бүртгэлтэй 234,948,434 төгрөгийн анхны өртөгтэй 4 авто машинд техникийн паспортыг хөтлөөгүй
Эрүүл мэнд	Эрдэнэмандал сумын эмнэлэг	Хүн	Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэл ангилалд бүртгэлтэй 239,700.000 төгрөгийн анхны үнэтэй 3 авто машинд техникийн паспорт хувийн хэрэг хөтлөөгүй.
Орон нутаг	Жаргалант ЗДТГ	сумын	Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 15 барилга болон 7 тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй.
Соёл	Жаргалант Соёлын төв	сумын	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Соёл	Жаргалант Соёлын төв	сумын	Байгууллагын эзэмшилд байгаа газрын гэрчилгээ, кадастрын зургийг шинэчилж системд оруулаагүй
Боловсрол	Жаргалант Хүүхдийн цэцэрлэг	сумын	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Боловсрол	Жаргалант Хүүхдийн цэцэрлэг	сумын	Байгууллагын эзэмшилд байгаа газрын гэрчилгээ, кадастрын зургийг шинэчилж системд оруулаагүй
Эрүүл мэнд	Жаргалант ЭМТөв	сумын	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 барилга, 4 авто машинд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Эрүүл мэнд	Жаргалант ЭМТөв	сумын	Байгууллагын эзэмшилд байгаа газрын гэрчилгээ, кадастрын зургийг шинэчилж системд оруулаагүй
Эрүүл мэнд	"Ар манал" ӨЭМТ		Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга болон тээврийн хэрэгслүүдэд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Эрүүл мэнд	"Ар манал" ӨЭМТ		Авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 12,000,000 төгрөгийн поробоксын тээврийн хэрэгслийн гэрчилгээ иргэн Амартүвшиний нэр дээр бүртгэлтэй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод дугаартай дэвсгэртэй болгоогүй.
Улсын төсвийн байгууллага	Зооноз судлалын төв	өвчин	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод дугаартай дэвсгэртэй болгоогүй.
Орон нутаг	Аймгийн ЗДТГ		Үндсэн хөрөнгөд барилга байгууламжид техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Орон нутаг	Ихтамир ЗДТГ	сумын	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Эрүүл мэнд	Ихтамир ЭМТөв	сумын	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Эрүүл мэнд	Ихтамир ЭМТөв	сумын	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Соёл	Ихтамир Соёлын төв	сумын	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Боловсрол	Ихтамир ЕБС	сумын	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй



Эрүүл мэнд	Хоршооллын ЭМТөв	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Эрүүл мэнд	Хоршооллын ЭМТөв	Барилга байгууламжид хувийн хэрэг үүсгээгүй
Боловсрол	Хүмүүн 1 дүгээр сургууль	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Боловсрол	Хоршооллын бага сургууль, цэцэрлэг	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга болон тээврийн хэрэгслүүдэд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Улсын төсвийн байгууллага	ХХААГ	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга болон тээврийн хэрэгслүүдэд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй
Орон нутаг	Хангай сумын ЗДТГ	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга болон тээврийн хэрэгслүүдэд техникийн паспорт хувийн хэрэг үүсгээгүй

Тайлангийн хавсралт №2

Хяналтын тооллогоор хөрөнгө дутагдуулсан байгууллагын жагсаалт

№	Салбарын харъяалал	Төсөвт байгууллагын нэр	Аудитаар илэрсэн зөрчлийн товч утга, хууль, журмын заалт	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Орон нутаг	Цэцэрлэг хотын хот тохижилт ААНТҮГ	Аудитаар хяналтын тооллого хийхэд 2ш ширээ, 2ш шкаф, 2 ш 3 үйлдэлтэй принтер, 1ш зөөврийн нотебүүк, 2ш туслах ширээ байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй	
2	Орон нутаг	Цэцэрлэг хотын хот тохижилт ААНТҮГ	Авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 5000,000 төгрөгийн өртөгтэй мазда, 58,250.000 төгрөгийн анхны үнэтэй авто сонсма, 3,000.000 төгрөгийн анхны үнэтэй портер авто авто машин мотор болон бусад сэлбэг хэрэгсэл тоногдсон	66,250,000.0
3	Орон нутаг	Цэцэрлэг хотын хот тохижилт ААНТҮГ	Мөн 148,800.000 төгрөгийн анхны үнэтэй 50-ковш авто машин хогийн цэг дээр мотор болон бусад сэлбэг хэрэгслүүд тоногдсон	148,800,000.0
4	Орон нутаг	Цэцэрлэг хотын хот тохижилт ААНТҮГ	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 159,496,892 төгрөгийн үнэтэй 9ш хогийн цэгийн нягтаршуулах тоног төхөөрөмжүүд тоногдож алдагдсан. Хяналтын тооллогоор байхгүй.	159,496,892.0
5	аймгийн ТЕЗ-ийн байгууллага	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Барилга байгууламжид бүртгэлтэй 4,626.720 төгрөгийн анхны үнэтэй Булган сумын хэвтээгийн довд байрлах байгаль хамгаалагчийн байр хяналтын тооллогоор бодитоор оршин байхгүй	4,626,720.0
6	аймгийн ТЕЗ-ийн байгууллага	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 2010 оноос 2018 онд бүртгэсэн 26ш мотоцикл нь хяналтын тооллогоор бодитоор оршин байхгүй үрэгдэж утсан.	
7	аймгийн ТЕЗ-ийн байгууллага	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Мөн байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 3,500.000 төгрөгийн трактор тээврийн хэрэгсэл нь хяналтын тооллогоор бодитоор оршин байхгүй. Холбогдох албан хаагчийн тайлбараар 2014 оноос хойш байхгүй 2,500.000 төгрөгөөр хувь иргэнд зарагдсан мэдээлэлтэй.	3,500,000.0
8	Боловсрол	Хүмүүн 2 дугаар сургууль	ОНӨГ-т актлуулахаар хүргүүлсэн хөрөнгөд хяналтын тооллого хийхэд эвдэрсэн гэх 1ш хөргөгч, 1ш цахилгаан пийшин, 228ш аяга, 40ш халбага, хусуур,	



			хувцас хатаагч зэрэг хөрөнгүүд нь бодитоор оршин байхгүй	
9	Орон нутаг	Батцэнгэл сумын ЗДТГ	5.6 сая төгрөгийн анхны үнэтэй трактор хяналтын тооллогод хамрагдаагүй орон нутгийн өмчид байхгүй	5,600,000.0
10	Эрүүл мэнд	Хайрхан сумын ЭМТөв	Байгууллагад 2020 онд ашиглалтад хүлээн авсан 7,840,000 төгрөгийн 4ш мотоцикл бодитоор оршин байхгүй 1 арам, 2 банк тоологдсон, хөрөнгө шамшигдуулсан байх эрсдэл үүссэн	7,840,000.0
11	Эрүүл мэнд	Эрдэнэмандал сумын Хүн эмнэлэг	Тавилга эд хогшилд бүртгэлтэй 4,301.492 төгрөгийн анхны үнэтэй 122 ширхэг хөрөнгийг, машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 17,041.427 төгрөгийн анхны үнэтэй 4 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийг тус тус дутагдаж үрэгдсэн	21,342,919.0
12	Орон нутаг	Жаргалант сумын ЗДТГ	Авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 2019 оны 9,350.000 төгрөгийн анхны үнэтэй 5ш мотоцикл, 2020 оны 9,990.905 төгрөгийн үнэтэй 5 ш мотоциклийг хүлээлгэн өгсөн албан хаагчдаас аваагүй хяналтын тооллогод хамрагдаагүй	9,990,905.0
	Нийт			427,447,436.00

Тайлангийн хавсралт №3

Өмч хамгаалах зөвлөлийн тайланг архивын нэгж үүсгээгүй байгууллагын жагсаалт

Салбарын харьяа	Төсөвт байгууллагын нэр	Аудитаар илэрсэн зөрчлийн товч утга, хууль, журмын заалт
Эрүүл мэнд	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллого болон, өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Орон нутаг	Цэцэрлэг хотын тохижилт ААНТҮГ	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Боловсрол	Батцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэг	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Соёл	Батцэнгэл сумын Соёлын төв	Байгууллагын 2023, 2024 оны өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Соёл	Өлзийт сумын Соёлын төв	Байгууллагын 2023, 2024 оны өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Боловсрол	Өлзийт сумын ЕБС	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Эрүүл мэнд	Өлзийт сумын ЭМТөв	Байгууллагын 2023, 2024 оны өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Орон нутаг	Хайрхан сумын ЗДТГ	Байгууллагын 2023, 2024 оны өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Соёл	Эрдэнэмандал сумын Соёлын төв	Байгууллагын 2023, 2024 оны өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Орон нутаг	Жаргалант сумын ЗДТГ	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Эрүүл мэнд	"Ар манал" ӨЭМТ	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Улсын төсвийн байгууллага	Зооноз өвчин судлалын төв	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын тайланг архивын нэгж үүсгээгүй
Боловсрол	Хоршооллын бага сургууль, цэцэрлэг	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй
Соёл	Хангай сумын соёлын төв	Байгууллагын 2023, 2024 оны эд хөрөнгийн тооллогын болон өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж үүсгээгүй

Монгол улс, Архангай, Эрдэнэбулган сум

2 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр

Утас: 70333141. Факс: +976 70333141

И-мэйл: Arkhangai@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn